



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 30

Алтай

**Комисс байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 91 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Зуны Баруун бүсийн хурдан морины уралдааныг 2016 оны 07 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд Алтай хотод зохион байгуулах тул Засагт хан аймаг байгуулагдсаны 458 жил, Ардын хувьсгалын 95 жил, Говь-Алтай аймаг байгуулагдсаны 93 жилийн ойн баяр наадмыг хамтатган тэмдэглэн өнгөрүүлэхээр тогтсугай.

2. Зуны Баруун бүсийн хурдан морины уралдаан, Засагт хан аймаг байгуулагдсаны 458 жил, Ардын хувьсгалын 95 жил, Говь-Алтай аймаг байгуулагдсаны 93 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Тус наадмыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2016 оны 06 дугаар сард багтаан батлуулж, бүсийн аймгуудын төлөөлөлтэй хяналтын зөвлөл, салбар хороодын бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж, зохион байгуулалтын өндөр түвшинд тэмдэглэн өнгөрүүлэхийг баяр наадмыг зохион байгуулах хорооны дарга, аймгийн Засаг дарга /О.Амгаланбаатар/-д даалгасугай.

ДАРГА



А.ДЭЛГЭРЖАРГАЛ

ЗУНЫ БАРУУН БҮСИЙН ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН  
ЗАСАГТ ХАН АЙМАГ БАЙГУУЛАГДСАНЫ 458 ЖИЛ, АРДЫН ХУВЬСГАЛЫН 95 ЖИЛ,  
ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ БАЙГУУЛАГДСАНЫ 93 ЖИЛИЙН ОЙН АЙМГИЙН БАЯР НААДМЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

**1. Зохион байгуулах аймгийн хорооны бүрэлдэхүүн:**

Дарга: Аймгийн Засаг дарга

Дэд дарга: -Иргэн, нийгмийн хөгжлийн бодлого эрхэлсэн орлогч  
-Эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийн бодлого эрхэлсэн орлогч

Гишүүд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга  
-Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга  
-Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга  
-Хууль зүйн хэлтсийн дарга  
-Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга  
-Цэргийн штабын дарга, хурандаа  
-Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга  
-Мэргэжлийн хяналтын газрын дарга  
-Биеийн тамир, спортын газрын дарга  
-Эрүүл мэндийн газрын дарга  
-Боловсрол, соёлын газрын дарга  
-Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга  
-Цагдаагийн газрын дарга  
-Онцгой байдлын хэлтсийн дарга  
-Хүнс, хөдөө аж ахуй, газрын дарга  
-Татварын хэлтсийн дарга  
-Улсын бүртгэл, статистикийн газрын дарга  
-Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга  
-“Нийтлэг үйлчилгээ”- ОНТҮГ-ын дарга  
-Нэгдсэн эмнэлгийн дарга  
-Орон нутгийн өмчийн албаны дарга  
-Ардын дуу бүжгийн “Алтай” чуулгын дарга  
-Олон нийтийн “Алтай”радиоогийн захирал  
-Есөнбулаг сумын ИТХ-ын дарга  
-Есөнбулаг сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: -Нийгмийн хөгжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

- Нийгмийн хөгжлийн хэлтсийн Боловсрол, соёлын бодлого  
хариуцсан мэргэжилтэн

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ  
АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2016.05.23

№06

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1.	Хуралдааны тов зарлах тухай	А.Дэлгэржаргал		Тогтоол 31

**ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН АЖЛЫН АЛБА**